



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.24 № 289

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ХҮРМЭН СУМЫН ЖАНЖИГОВЬ  
ОНӨААТҮГ-Т**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд 2022 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитын тайлан, дүгнэлт, албан шаардлагыг хүргүүлж байна.

Хавсралт 18 хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц. ӨСӨХБАЯР



D/Явсан Бичиг/2023он/2023-03-24.Doc

016030210



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ХҮРМЭН СУМЫН ЖАНЖИНГОВЬ  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
А.МЭНДБАЯР ТАНАА

2023-03-15 № 241  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хүрмэн сумын Жанжинговь ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хүрмэн сумын Жанжинговь ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1, 2-д заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд 0.1 сая төгрөгийн авлага, 19.1 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан 5.4 сая төгрөгийн бараа материал, 29.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тооллогоор баталгаажуулаагүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас 11.8 сая төгрөгийн санхүүжилтээр тоног төхөөрөмж худалдан авч үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

016020337

## **Аудитын гол асуудал**

Тайлант онд 44.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 40.1 сая төгрөгийг зарцуулж, 4.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 187/А 164 11 14  
ӨМА-2023/27/НА-СТА-ОНА

Даланзадгад сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүрмэн сумын “Жанжинговь” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд тусгасан 484,360.00 төгрөгийн авлага, 19,160,873.60 төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 5,464,907.23 төгрөгийн бараа материал, 29,304,052.64 төгрөгийн үндсэн хөрөнгөнд тооллого хийж, тооцоо бодоогүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1/ "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор", 2/ "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" заалтыг тус тус нийцэхгүй байна.- д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1,2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.2.2-д заасныг тус тус хэрэгжүүлэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

016040571

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүрмэн сумын Жанжинговь ОНӨААТҮГ-ын захирал (А.Мэндбаяр), нягтлан бодогч (Т.Наранбат) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Т.БУДСҮРЭН



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Жанжин говь ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2023/27/НА-СТА-ОНА**

Цахим хуудас:  
[www.Umnu.govi@audit.mn](http://www.Umnu.govi@audit.mn)

Өмнөговь аймаг  
2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: [usukhbayarts@audit.gov.mn](mailto:usukhbayarts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: [Khongorzult@audit.gov.mn](mailto:Khongorzult@audit.gov.mn)  
Аудитор: Т.Будсүрэн  
Утас: 70533552 Цахим хаяг: [budsurent@audit.gov.mn](mailto:budsurent@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	8
4. Аудитын тайлан.....	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Материаллаг байдал.....	9
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
5. Аудитын илрүүлэлт.....	11
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн Газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.15 № 241

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хүрмэн сумын Жанжинговь ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хүрмэн сумын Жанжинговь ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1, 2-д заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд 0.1 сая төгрөгийн авлага, 19.1 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан 5.4 сая төгрөгийн бараа материал, 29.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тооллогоор баталгаажуулаагүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас 11.8 сая төгрөгийн санхүүжилтээр тоног төхөөрөмж худалдан авч үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

016020337

## **Аудитын гол асуудал**

Тайлант онд 44.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 40.1 сая төгрөгийг зарцуулж, 4.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,081,488.06</b>	<b>5,974,200.51</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	49,282.87	24,933.28
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	49,282.87	24,933.28
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	49,282.87	24,933.28
31212	Монгол банкин дахь харилцах	49,282.87	24,933.28
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	484,360.00	484,360.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	484,360.00	484,360.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	3,547,845.19	5,464,907.23
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,547,845.19	5,464,907.23
35130	Эм боох материал	3,547,845.19	5,464,907.23
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,414,251.29</b>	<b>23,329,852.13</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12,414,251.29	23,329,852.13
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	11,914,251.29	22,929,852.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	13,795,448.93	13,795,448.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,881,197.64)	(2,508,263.52)
39205	Машин тоног төхөөрөмж		5,100,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(84,999.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		6,740,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(112,333.33)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	500,000.00	400,000.04
39301	Програм хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(99,999.96)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>16,495,739.35</b>	<b>29,304,052.64</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>11,104,543.90</b>	<b>19,160,873.60</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	11,104,543.90	19,160,873.60
<b>413</b>	<b>Өглөг</b>	11,104,543.90	19,160,873.60
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	11,104,543.90	19,160,873.60
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	11,104,543.90	19,160,873.60
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,391,195.45</b>	<b>10,143,179.04</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,391,195.45	10,143,179.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	19,027,994.00	19,027,994.00
51101	Өмч: - төрийн	19,027,994.00	19,027,994.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(19,586,847.48)	(14,143,179.04)
51210	Өмнөх үеийн үр дүн	(19,586,847.48)	(14,143,179.04)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,950,048.93	30,765,129.67
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>16,495,739.35</b>	<b>29,304,052.64</b>

## 2.2 Аудит хийсэн ор дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	43,811,273.40	44,856,508.99
11	ТАТВАРЫН ОРЛОГО	43,811,273.40	44,856,508.99
110	Орлогын албан татвар	43,811,273.40	44,856,508.99
1100	Хувь хүний орлогын албан татвар	43,811,273.40	44,856,508.99
110002	Үйл ажиллагааны орлого	43,811,273.40	44,856,508.99
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	44,392,304.53	39,576,527.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	44,392,304.53	39,576,527.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,392,304.53	39,576,527.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,266,000.00	10,266,000.00
210101	Үндсэн цалин	10,266,000.00	10,266,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,314,048.24	1,262,712.24
210201	Тэтгэврийн даатгал	1,314,048.24	1,262,712.24
2104	Хангамж, бараа материалын зардал	-	60,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	60,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,084,744.41	27,063,416.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	219,172.80	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	65,700.00	61,456.18
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	31,799,871.61	27,001,959.82
210813	Бусад зардал /ТӨҮГ/	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	727,511.88	924,399.16
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	727,511.88	924,399.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(581,031.13)	5,279,981.59
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(581,031.13)	5,279,981.59

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	43,751,273.40	44,856,508.99
11	ТАТВАРЫН ОРЛОГО	43,751,273.40	44,856,508.99
110	Орлогын албан татвар	43,751,273.40	44,856,508.99
1100	Хувь хүний орлогын албан татвар	43,751,273.40	44,856,508.99
110002	Үйл ажиллагааны орлого	43,751,273.40	44,856,508.99
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	43,769,672.17	44,880,858.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,769,672.17	44,880,858.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,769,672.17	44,880,858.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,110,662.00	7,429,925.00
210101	Үндсэн цалин	8,110,662.00	7,429,925.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	202,000.00
210201	Тэтгэврийн даатгал	-	202,000.00
2105	Норматив зардал	35,171,314.10	36,900,425.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,171,314.10	36,900,425.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	487,696.07	348,508.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,700.00	-
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	421,996.07	227,052.40
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	-	121,456.18

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(18,398.77)	(24,349.59)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,398.77	(24,349.59)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	67,681.64	49,282.87
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49,282.87	24,933.28

## 2.4 Аудит хийсэн цэвэр өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,027,994.00	5,950,048.93	-19,586,847.48	5,391,195.45
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,027,994.00	5,950,048.93	-19,586,847.48	5,391,195.45
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,027,994.00	5,950,048.93	-19,586,847.48	5,391,195.45
2022 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,027,994.00	5,950,048.93	-19,586,847.48	5,391,195.45
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,027,994.00	5,950,048.93	-19,586,847.48	5,391,195.45
Тайлант үеийн үр дүн			4,751,983.59	4,751,983.59
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,027,994.00	5,950,048.93	-14,834,863.89	10,143,179.04

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		67,681.64		49,282.87
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,769,672.17	43,769,672.17	44,880,858.58	44,880,858.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,769,672.17	43,769,672.17	44,880,858.58	44,880,858.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,769,672.17	43,769,672.17	44,880,858.58	44,880,858.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,110,662.00	8,110,662.00	7,429,925.00	7,429,925.00
210101	Үндсэн цалин	8,110,662.00	8,110,662.00	7,429,925.00	7,429,925.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	-	202,000.00	202,000.00
210201	Тэтгэврийн даатгал	-	-	202,000.00	202,000.00
2105	Норматив зардал	35,171,314.10	35,171,314.10	25,060,425.00	25,060,425.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,171,314.10	35,171,314.10	25,060,425.00	25,060,425.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	11,840,000.00	11,840,000.00
210604	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	11,840,000.00	11,840,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	487,696.07	487,696.07	348,508.58	348,508.58
210807	татварын байгууллагат төлсөн	421,996.07	421,996.07	227,052.40	227,052.40
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	65,700.00	65,700.00	121,456.18	121,456.18
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,751,273.40	43,751,273.40	44,856,508.99	44,856,508.99
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	43,751,273.40	43,751,273.40	44,856,508.99	44,856,508.99
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,751,273.40	43,751,273.40	44,856,508.99	44,856,508.99

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		67,681.64		49,282.87
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		49,681.64		24,933.28

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага үйл ажиллагааныхаа зорилгоо “ард иргэдийг эрүүл аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах үйл ажиллагаа явуулдаг байгууллага” гэж тодорхойлсон байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулаагүй, дотооддоо хяналт шалгалтын баг зохион байгуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын жанжин говь ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын жанжин говь ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан “Аж ахуй нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12.8 сая төгрөгөөр буюу 77 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	49,282.87	24,933.28	-24,349.59
Бараа материал	3,547,845.19	5,464,907.23	1,917,062.04
Үндсэн хөрөнгө	12,414,251.29	23,329,852.13	10,915,600.84
<b>Нийт хөрөнгө</b>	<b>16,495,739.35</b>	<b>29,304,052.64</b>	<b>12,808,313.29</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	19,027,994.00	4,429,396.51	0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>16,495,739.35</b>	<b>29,304,052.64</b>	<b>12,808,313.29</b>

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна. Бараа материал 1.9 сая төгрөг, үндсэн хөрөнгө 10.9 сая төгрөгөөр өссөн нь говийн оюу хөгжлийг дэмжих сангаас 11.8 сая төгрөгийн санхүүжилтээр авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

**3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дүгээр зүйлийн 1.2-д заасны дагуу “Жанжин говь” ОНӨААТҮГ-ын захирал А.Мэндбаяр нь зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангаж эдийн засгийн үр дүн, хүрэх түвшинг батлуулсан байна.

Гүйцэтгэлээр борлуулалтын орлогоор 44.8 сая төгрөг, нийт 44.8 сая төгрөгийг бүрдүүлж, 27.0 сая төгрөгийг зарцуулан, 17.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

**4.АУДИТЫН ТАЙЛАН**

**4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өмнөговь аймгийн Хүрмэн сумын жанжин говь ОНӨААТҮГ-н 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Будсүрэн гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Ж.Болормаа, чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын жанжин говь ОНӨААТҮГ-н 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 44.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлээгүй байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 147 мэдээлэл байршуулахаас 34 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”-д заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг үнэн зөв, тогтоосон хугацаанд тогтмол тусгаж байх зөвлөмж өгсөн.

### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудит хийгдээгүй болно.

### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	Байхгүй.				
Албан шаардлага	Байхгүй.				
Зөвлөмж	Байхгүй.				
<b>Нийт дүн</b>					

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 алдааг аудитын явцад залруулж, 89.7 сая төгрөгийн 3 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж, 34.7 сая төгрөгийн 2 алдааг дахин гаргахгүй байх 1 албан шаардлага өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт:

Аудитаар төлбөрийн акт гараагүй байна.

#### 5.2 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Санхүүгийн тайланд тусгасан 484,360.00 төгрөгийн авлага, 19,160,873.60 төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 5,464,907.23 төгрөгийн бараа материал, 29,304,052.64 төгрөгийн үндсэн хөрөнгөнд тооллого хийж, тооцоо бодоогүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн "1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор", 2/ "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" заалтыг хангаж ажиллаагүй байна. Зөрчлүүдийг арилгаж ажиллах албан шаардлага өгсөн.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт-1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж-1: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдүүлж ажиллах

2. Цахим төлбөрийн системтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт-2:

Өгсөн зөвлөмж-2: Цахим төлбөрийн системд худалдаж авсан бараа материалыг нэр төрлөөр бус бөөн дүнгээр шивэлт хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж-2: Бараа, үйлчилгээ худалдан авалт хийх тухай бүрд борлуулагчийн хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг кассын машинаас хэвлүүлэн авч анхан шатны баримтад хавсаргаж байх зөвлөмж өгсөн.

3. Шилэн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт-3: Шилэн дансны цахим хуудсанд 147 мэдээлэл байршуулахаас 34 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж-3: Мэдээллийг тогтоосон хугацаанд, шуурхай мэдээлдэг байх зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дун		
							Тоо	Дун	Тоо	Дун				
Орлого үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй	1	89,737,367.57	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	89,737,367.57
<b>Дун</b>	<b>2</b>	<b>89,737,367.57</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>89,737,367.57</b>

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	АТ-НЫ тоо	Тоо	Дун
Өглөг, авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгөнд тооллого хийгээгүй.	2	54,414,193.47	0	0	1	54,414,193.47	0	0	0	0	0	0

Цахим төлбөрийн системд худалдаж авсан бараа материалыг нэр төрлөөр бус бөөн дүнгээр шивэлт хийсэн	1	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>54,414,193.47</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>54,414,193.47</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/												
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
Шилэн дансны цахим хуудсанд 147 мэдээлэл байршуулахаас 34 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан	1	0							1				0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0</b>							<b>1</b>				<b>0</b>